

**ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ЗАСГИЙН ГАЗРЫН ЗАРИМ ЧИГ ҮҮРГИЙГ ОРОН
НУТАГТ ТӨЛӨӨЛӨН 2022 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ГЭРЭЭНИЙ ХҮРЭЭНД АВЧ
ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2022 оны 7 дугаар сарын 18-ны өдөр

Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн 2022 онд хэрэгжүүлэх гэрээний хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний эхний хагас жилийн хэрэгжилтэд Монгол улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт– шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.7-г үндэслэн 6.3-т заасан аргачлалын дагуу явцын хяналт- шинжилгээ хийхэд эхний хагас жилийн байдлаар 81.2 хувийн хэрэгжилтийн явцтай байна.

Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн 2022 онд хэрэгжүүлэх гэрээний хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний эхний хагас жилд Бодлогын баримт бичиг, хууль тогтоол шийдвэрийн хэрэгжилт байгууллагын үйл ажиллагааны биелэлтийг 2022 онд тайлагнах хугацааны дагуу 12 гэрээний хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийж, холбогдох яамдад хүргүүлсэн.

/Тайлагнах хугацаа болон хэлтэс агентлагт хариуцуулсан хүснэгтийг хавсаргав/

Гэрээний хэрэгжилтийн явцын үнэлгээг хүснэгтээр харуулбал:

№	Яам /сайд/-ын нэр	заалтын тоо	дундаж хувь
1	БШУЯам	70	82
2	Эрчим хүчний яам	14	82.1
3	Барилга хот байгуулалтын яам	100	88
4	Эрүүл мэндийн яам	31	61.5
5	Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам	61	67.5
6	БОАЖЯам	60	61.5
7	Хууль зүй дотоод хэргийн яам	33	85.5
8	Батлан хамгаалах яам	31	94.6
9	Соёлын яам	65	91.2
10	ЗГХЭГазар	24	87.2
11	ЭЗХСайд	9	90
12	Гадаад харилцааны сайд	9	83.3
	Дүн	507	81.2

Гэрээний үүргийн хэрэгжилтийг сүүлийн 3 жилийн эхний хагас жилээр харуулбал:

д/д	Яам /сайд/-ын нэр	2019 он Эхний хагас жил	2020 он Эхний хагас жил	2021 он Эхний хагас жил	2022 он эхний хагас жил
1	Монгол улсын Шадар сайд	-	74.7	-	-
2	Уул уурхай хүнд үйлдвэрийн сайд	-	87.6	-	-
3	ЗГХЭГ-ын дарга	89.5	-	-	87.2
4	БШУЯам	89.2	64.8	89.4	82
5	Эрчим хүчний яам	60.6	68.3	69.1	82.1
6	Барилга хот байгуулалтын яам	68.2	76	76.6	88
7	Эрүүл мэндийн яам	77.9	91	86	61.5
8	Зам тээврийн хөгжлийн яам	-	-	-	-
9	ХХААХҮяам	67.1	83.3	-	-
10	Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам	56	83	76.6	67.5

11	БОАЖЯам	58.5	-	67.2	61.5
12	Сангийн яам	92	-	-	-
14	Хууль зүй дотоод хэргийн яам	81.6	82	72	85.5
15	Үндэсний хөгжлийн газар	89.2	90.5	-	-
16	Соёлын яам	-	-	71.1	91.2
17	Батлан хамгаалах яам	-	-	82	94.6
18	Гадаад харилцааны сайд	-	-	-	83.3
19	ЭЗХСайд	-	-	-	90
20	Дүн	69.1	80.1	76.6	81.2

2022 онд байгуулсан гэрээний заалтаас эхний хагас жилд хэрэгжилт удаашралтай болон хугацаа болоогүй заалтууд

№	Заалт	Биелэлт	Хувь
Нэг. Боловсрол, шинжлэх ухааны яам			
1	3.1.5. Аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар жилд хоёроос доошгүй удаа тухайн орон нутгийн боловсролын асуудлыг хэлэлцүүлж гарсан үр дүнгийн дагуу арга хэмжээ авах;		ХБ
2	3.2.21. Сургуулийн гадна байгаа хүүхэд болон сургууль завсардсан хүүхэд, залуучуудад боловсрол нөхөн олгох, тэднийг ерөнхий боловсролын сургуульд шилжүүлэн суралцуулах ажлыг нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллах;		50
3	3.3.13. Сургууль, дотуур байр, цэцэрлэгийн барилгын шилжин хэрэгжиж байгаа дуусаагүй барилга байгууламжийн үлдэгдэл санхүүжилтийг 2023 оны улсын төсөвт бүрэн тусгуулж, барилга байгууламжийг 2023 онд багтаан ашиглалтад бүрэн оруулах арга хэмжээний төлөвлөгөөг гарган, хамтран ажиллах;		хб
4	3.4.2. Аймаг, орон нутагт шинжлэх ухаан, инноваци, технологийг хөгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, батлан шаардагдах зардлыг орон нутгийн жил бүрийн төсөвт тусган санхүүжүүлж, хэрэгжилтийг хангах		ХБ
5	3.4.3. Аймаг, орон нутгийнхаа байгалийн болон бусад нөөцөд тулгуурласан, шинжлэх ухаан, технологийн үр дүнд суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх;	Дундговь аймаг дахь Политехник коллежийн барилгын мэргэжлийн сургалтын үйл ажиллагааг зах зээлийн эрэлт хэрэгцээ, барилгын салбарт шинээр нэвтэрч эхэлж буй техник технологийн дэвшилд нийцүүлэн, оновчтой зохион байгуулах зорилгоор олон улсын жишигт нийцсэн барилгын чадамжийн төвийг байгуулах төслийг Пассив Барилгын Хүрээлэн ТББ-тай хамтран боловсруулж байна.	50
6	3.4.6. Шинжлэх ухаан, технологи, инновацийн салбарт оруулж буй санхүүжилтийг бүртгэлжүүлэх, санхүүжилтийн хэмжээг нэмэгдүүлэхэд чиглэсэн санал санаачилга гаргах;		0

7	3.4.7. Эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургууль, хувийн хэвшилтэй хамтран шинэ санал, санаачилга, хамтарсан төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, грант олгох;		0
8	3.4.9. Тухайн орон нутгийн иргэдийн үүсгэн байгуулсан гарааны компанид санхүүгийн дэмжлэг үзүүлэх, гарааны бизнес эрхлэх, хөгжүүлэхэд чиглэсэн сургалтыг үе шаттай, тогтмол зохион байгуулах;		0
9	3.4.10. Аймаг, орон нутгийн онцлогт тулгуурлан байгаль, нийгмийн шинжлэх ухааны танин мэдэхүйн контентыг бүтээж, орон нутгийн болон үндэсний олон нийтийн радио телевиз, хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээн дэлгэрүүлэх;		0
10	3.4.11. "Моп X-Prize" санаачилгын хүрээнд аймаг, дүүргийн хэмжээнд тулгарч буй асуудлыг шинжлэх ухаанчаар шийдсэн 1 инновацийн төслийг иргэдийн оролцоотой нээлттэй сонгон шалгаруулж, грант олгох ажлыг орон нутгийн хэмжээнд зохион байгуулах;		0
Эрчим хүчний яам			
1	Аймгийн төвд шинээр дулааны станц барихтай холбогдуулан дулааны станц болон дулаан дамжуулах төвүүдийн цахилгаан хангамж, цэвэр, бохир ус, холбоо мэдээлэл, дулааны 2 хэлхээний шугам сүлжээний зураг төслийн ажлыг эхлүүлж, улсын төсөвт тусгах талаар арга хэмжээ авч ажиллах	Эрчим хүчний яам "10 аймгийн төвд дулааны станц барих төсөл"-ийн төсөл хэрэгжүүлэх нэгж дээр 2022 оны 03 дугаар сарын 25-нд тендер нээж, үнэлэх шатандаа явагдаж байна. 2022 оны улсын төсөвт тусгуулсан боловч хөрөнгийн асуудал шийдвэрлээгүй. Ажлын зураг, төсөв боловсруулан магадлалаар хянагдан "10 аймгийн төвд дулааны станц барих төсөл"-ийн төсөл хэрэгжүүлэх нэгжид 1 хувь хүлээлгэн өгсөн. 2023 оны улсын төсөвт тусгуулахаар ажиллаж байна. Төсөвт өртөг нь 36 тэрбум төгрөг.	50
2	Төвөгшил бага болон дунд зэргийн эрчим хүчний барилга байгууламжийг техникийн болон улсын комисст хүлээж авахад тухайн орон нутгийн эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх тусгай зөвшөөрөл бүхий үйлдвэр компаниудын мэргэжлийн хүмүүсийг оролцуулах.	Хагас жилийн байдлаар ашиглалтад орсон төсөл арга хэмжээ байхгүй байна. Хугацаа болоогүй	ХБ
Барилга хот байгуулалтын яам			
1	"Монгол Улсын Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл" боловсруулахад шаардлагатай мэдээ, мэдээллээр тухай бүр хангах, уг төслийн хүрээнд хэлэлцүүлэг зохион байгуулахад дэмжлэг үзүүлж, хамтарч ажиллах		ХБ
2	Аймаг, сумдын барилга байгууламж, тохижилт, ногоон байгууламж инженерийн дэд бүтцийн өгөгдлийн санг бүрдүүлэх, хот байгуулалтын кадастрын мэдээллийн нэгдсэн системийн нэмэлт хөгжүүлэлт, сайжруулалт хийж,	Аймгийн төвийн 280 барилга, байгууламжийн мэдээллийг хот байгуулалтын кадастрын мэдээллийн санд бүртгэж, 14 сумын 381 барилга, байгууламжийн мэдээллийг цаасан байдлаар бүрдүүлсэн. Орон нутгийн	30

	хэрэглээнд нэвтрүүлэх ажлыг ГЗБГЗЗГ-тай хамтран хэрэгжүүлэх	төсвийн 150,0 сая төгрөгөөр “Дундговь аймгийн хэмжээнд хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн өгөгдөл бүрдүүлж, мэдээллийн санд бүртгэх” зөвлөх үйлчилгээний тендерийг зарлан, гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан. Тус ажлын хүрээнд аймгийн төв болон 14 сумын хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн суурь өгөгдөл бүрэн хийгдэнэ.	
3	Бүсийн тулгуур төв, аймгийн төв хотууд болон сумын төвийн батлагдсан хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний “Хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г холбогдох хууль тогтоомжийн дагуу боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангах ажлыг үе шаттайгаар зохион байгуулж, тайлагнах	Мандалговь хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд инженерийн бэлтгэл арга хэмжээг хангах, ус, цахилгаан, дулаан хангамжийн найдвартай эх үүсвэр, шугам сүлжээ, цэвэрлэх байгууламж, гол замын сүлжээнээс эхлэн барьж байгуулахаар улсын төсөв, гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр хийж гүйцэтгэхээр тусгаснаас дараах ажлуудыг гүйцэтгэсэн. Үүнд - Дулааны станцын барилга 2-р хэлхээний зургийн даалгаврыг боловсруулахад хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулж мэргэжлийн байгууллагуудын саналыг тусгаж батлуулсан. Зураг төслийг магадлалаар баталгаажуулж хүлээн авсан. - “Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн 13713-мон төсөл”-ийн хүрээнд аймгийн төвд хоногт 3000м3 хүчин чадалтай биологи цэвэрлэгээтэй цэвэрлэх байгууламж болон гэр хорооллын 5,57 км ариутгах татуургын шугам сүлжээний барилга угсралтын ажлыг “Сайн констракшн” ХХК, түншлэлээр “Сан” ХХК гүйцэтгэж байгаа бөгөөд ажлын явц 95 хувьтай үргэлжилж байна.	30
4	Монгол Улсын Үндсэн хууль, Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуульд нийцүүлэн хот, суурин газарт улс, орон нутгийн зэрэглэл тогтоох эрх зүйн орчныг бүрдүүлэхэд шаардлагатай судалгаа, тооцоог гаргаж холбогдох газарт хүргүүлэх		ХБ
5	Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах		ХБ
6	2022 онд иргэнд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалтын талаар гарсан Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах	2022 онд аймгийн хэмжээнд нийт 1452 иргэнд 111,86 га газар өмчлүүлэхээр төлөвлөснөөс хагас жилийн байдлаар 477 иргэнд 36,72 га газрыг өмчлүүлсэн ба тогтоолын хэрэгжилт 32,8 хувьтай байна.	30
7	Аймаг, нийслэлийн хэмжээнд 2023 онд иргэнд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалтын саналыг тогтоож аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах	Газар зохион байгуулалтын системд 2023 онд иргэнд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалтын саналын төслийг үүсгэн зураг төслийг боловсруулан иргэдээс санал авч байна.	50

8	Төрийн өмчийн газрын хариуцагчтай гэрээ байгуулж, гэрээний үүргийн биелэлтийг хангаж ажиллах		ХБ
9	Газрын тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.7-д заасан Газрын төлөв байдал, чанарын төлөвлөгөөт хянан баталгааны ажлыг аймгийн хэмжээнд орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэн хийх ажлыг зохион байгуулах	2022 оны орон нутгийн төсөвт 50,000,000 төгрөгийн хөрөнгөөр аймгийн 15 сумын хот, суурин газрын төлөв байдал, чанарын төлөвлөгөөт хянан баталгаа хийх зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг шалгаруулах тендэр сонгон шалгаруулалт явагдаж гүйцэтгэгч байгууллагаар "Вектор Мэп" ХХК шалгарч гэрээ байгуулах шатанд явагдаж байна.	30
10	Бэлчээрийн газрын өөрчлөлт, доройтлыг фото мониторингийн аргаах үнэлэх ажлыг тасралтгүй зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх, ажлын үр дүнг орон нутгийн байгууллага, иргэд, олон нийт болон малчид, тариаланчдад хүргэж, үйл ажиллагаандаа ашиглахад удирдлага, чиглэлээр хангаж ажиллах		ХБ
11	Нутаг дэвсгэрийн хэмжээнд Монгол Улсын Их Хурлын 2003 оны 42 дугаар тогтоолоор батлагдсан газар зүйн нэрийн хэрэглээнд хяналт тавих, тогтоолын 2 дахь хэсгийн 2 дахь заалтын дагуу аймгийн түвшинд газар зүйн нэрийн тодруулалтын ажлыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах, холбогдон гарах төсөв, зардлыг 2022, 2023 оны орон нутгийн төсөвт тусган ажиллах, Газар зүйн нэрийн салбар зөвлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх.	2022 онд тус аймгийн Адаацаг, Дэлгэрхангай, Эрдэнэдалай, Дэлгэрцогт, Сайхан-Овоо, Цагаандэлгэр сумдын газар зүйн нэрийн хээрийн тодруулалт хийх, нэрийн мэдээллийн сан байгуулах ажлыг хийлгэхээр ОНХСангийн хөрөнгөд 72.0 сая төгрөгийн төсвийг батлуулсан. Тус сумдын газар зүйн нэрийн хээрийн тодруулалтын ажил хийгдэхээр ОН-ийн төсөвт батлагдсан. Тус аймгийн 6 сумын газар зүйн нэрийн хээрийн тодруулалт хийх ажлын даалгаврыг батлуулан холбогдох сумдад хүргүүлсэн. 2 сум гэрээ байгуулсан. 4 сум гэрээ байгуулах шатанд байна	30
12	Сумдын газрын даамалд хадгалагдаж байгаа нэгж талбарын хувийн хэргийн баримтыг аймгийн ГХБХБГ-ын байгууллагын архивд татан төвлөрүүлэхэд шаардлагатай санхүүгийн асуудлыг шийдвэрлэн, дэмжлэг үзүүлэх.	Сумдын нэгж талбарын хувийн хэргийг байгууллагын архивд татан төвлөрүүлэх ажлын хүрээнд 2022 оны 03 дугаар сарын 28-ны өдөр ГЗБГЗЗГазрын Архив мэдээллийн төвтэй очиж танилцан, туршлага судлан, сумдын Газрын даамлуудад нэгж талбарын хувийн хэргийн бүртгэл, бүрдлийг хэрхэн хангах талаар заавар, зөвлөмж өгсөн.Тус ажлын хүрээнд архивын өрөөнд шинээр 2 ширхэг нягтруулсан шүүгээг 6,800,000 төгрөгөөр худалдан авсан бөгөөд өрөө тасалгааг засварлаж стандарт орчин бүрдүүлж байна. 2022 оны 3-4 дүгээр улиралд архивын өрөөний стандарт орчин бүрдүүлэн сумдаас нэгж талбарын хувийн хэргийг татан авахаар ажиллаж байна.	50
13	Төрийн болон албаны нууцыг хадгалж хамгаалах, холбогдох хууль журмыг хэрэгжүүлэх үйл ажиллагаатай холбоотой хийгдэж байгаа ажилд хяналт тавих заавар зөвлөмж өгөх.	Төрийн болон албаны нууцыг хадгалж хамгаалах талаар хийгдсэн ажлын 2021 оны мэдээг 2022 оны 01 дүгээр сард хүргүүлсэн. 2022 оны мэдээг 12 дугаар сард хүргүүлнэ.	ХБ

14	Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн 18 дугаар зүйлд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх.		ХБ
15	УИХ-ын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 6.2.7-д “Аймгуудад эхний ээлжийн инженерийн шугамыг шинэчлэх, шинээр барих, хүчин чадлыг нэмэгдүүлэх арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлж, “Сумдын хөгжил” арга хэмжээг хэрэгжүүлэх.	2022 оны улсын төсвийн хөрөнгөөр Сайхан-Овоо сумын төвийн усан хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, барилга байгууламж ажилд 2,214.4 сая төгрөг, Сумын хөгжил, инженерийн дэд бүтцийн хангамж төсөл /Дундговь, Луус/ ажилд 4,000.0 сая төгрөг баталсан. Мөн Барилга, хот байгуулалтын сайдын багцаас “Мандал хороолол”-ын гадна шугам сүлжээ, халаалтын зуухны барилга угсралтын ажил /Дундговь, Сайнцагаан/ ажлыг 500 сая төгрөг, “Түмний хороолол” болон “Хаус хороолол”-ын гадна 2.0 км ариутгах татуургын шугам сүлжээний ажил /Дундговь, Сайнцагаан/ ажилд 800 сая төгрөг батлан тендерийн шатандаа явагдаж байна. Луус сумын төвийн усан хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, барилга байгууламжийн ажлыг “Бурхант хясаат” ХХК 3,995.0 тэрбум төгрөгөөр гэрээ байгуулсан бэлтгэл ажлын шатанд байна	30
16	Ундны усны аюулгүй байдлын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, төлөвлөгөөг шинэчлэн сайжруулах.	Ундны усны аюулгүй байдлын төлөвлөгөөг “Дундговь-Ус” ОНӨААТҮГ-тай хамтран боловсруулж байна.	30
17	Инженерийн дэд бүтцийн мэдээллийн сан бүрдүүлэх, тогтмол шинэчлэл хийх, боловсронгуй болгох ажлыг зохион байгуулах, зохицуулах, хэрэглэгчийг мэдээллээр хангах.		ХБ
18	Засгийн газрын 2019 оны 138 дугаар тогтоолын дагуу “Улс орон нутгийн төсөв, гадаад, дотоодын зээл, буцалтгүй тусламж, хувийн хэвшлийн хөрөнгө”-өөр баригдсан түрээслэх, түрээслүүлээд өмчлүүлэх зориулалт бүхий орон сууцанд зорилтод бүлгийн иргэдийг хамруулах хүрээнд тухай бүр иргэдийн хүсэлтийг авч, холбогдох журмын дагуу нээлттэй, ил тод шийдвэрлэж ажиллах, улирал бүр тус яаманд тайлан, мэдээ ирүүлэх	Тус аймгийн хэмжээнд гадна инженерийн шугам сүлжээг улс, орон нутгийн төсөв, гадаадын хөрөнгө оруулалтаар гүйцэтгэсэн орон сууцны хороололд шинээр баригдах орон сууцны барилгын нийт талбайн 2,0 хувийг орон нутгийн өмчид шилжүүлэн авах замаар орон нутгийн өмчит түрээсийн орон сууцны сан бүрдүүлэх хөтөлбөрийг боловсруулж, аймгийн ИТХ-ын 2021 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 03 дугаар тогтоолоор батлуулсан. Тус хөтөлбөр хэрэгжсэнээр төрийн албан хаагч, залуу гэр бүл зэрэг зорилтот бүлэгт зориулсан түрээсийн орон сууцны сан бүрдэнэ.	ХБ
19	Улс, орон нутгийн төсөв, төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан орон нутгийн өмчийн түрээсийн орон сууц санг нэмэгдүүлэх. Улирал бүр тус яаманд тайлан, мэдээлэл ирүүлэх.		ХБ
20	Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах, ашиглалтын шаардлага хангахгүй орон сууцыг буулган дахин барилгажуулах төслийн ажлыг	Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгын судалгааг гаргаж, дахин төлөвлөлт хийх боломжтой 1 төслийг	30

	эрчимжүүлэх, төсөлд шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлэх ажлыг нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангаж, хамтран ажиллах.	судалж байна. Мөн ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих үйл ажиллагааны журам, гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах үйл ажиллагааны журмыг иргэдэд танилцуулах, сурталчлах ажлыг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зохион байгуулж байна.	
21	Газар хөдлөлт болон галд тэсвэртэй, хөрсний бохирдолгүй, ариун цэврийн болон эрчим хүчний хэмнэлттэй норм, дүрэм, стандартын шаардлага хангасан, тухайн орон нутгийн цаг уур, бүс нутгийн онцлогт тохирсон, хямд өртөг бүхий амины орон сууцны иж бүрэн нэг маягийн загвар зургийг “Барилгын хөгжлийн төв” ТӨААТҮГ-тай хамтран боловсруулж батлуулан, иргэдэд үнэ төлбөргүй ашиглуулах	Хямд өртөг бүхий амины орон сууцны иж бүрэн нэг маягийн загвар зураг төсөл “Барилгын хөгжлийн төв” ТӨААТҮГ-т магадлалаар хянагдаж байна	30
	Монгол Улсын Их хурлын 2016 оны 34 дүгээр тогтоолоор батлагдсан “Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолын 5 дахь заалт “орон сууц, сургууль, цэцэрлэг, эмнэлгийн барилга байгууламжийн чанар, газар хөдлөлтөд тэсвэрлэх байдлыг шалгаж, барилга байгууламжийг паспортжуулах ажлыг дуусгах, газар хөдлөлтөд тэсвэргүй барилгыг буулгаж шинээр барих, ашиглах боломжтой барилгуудыг үе шаттайгаар бэхэлж хүчитгэх ажлыг зохион байгуулах”, паспортжуулахтай холбоотой багаж, тоног төхөөрөмж, техникээр хангах ажлыг зохион байгуулах	Тус тогтоолын 5 дугаар хавсралтад заасан ажлын хүрээнд аймгийн хэмжээнд ашиглагдаж буй сургууль, цэцэрлэг, эмнэлэг, орон сууцны барилгын судалгааг гаргасан. Судалгаагаар ашиглалтын шаардлага хангахгүй 8 барилга байгаагаас 2022 оны улсын төсөвт Сайнцагаан сумын 2 дугаар цэцэрлэгийг буулгаж шинээр 150 ортой цэцэрлэг, Сайнцагаан сумын Хүмүүнлэг сургуулийн барилгыг буулгаж, шинээр 640 суудалтай сургууль, спорт заалны барилга барихаар хөрөнгийг батлуулсан бөгөөд гүйцэтгэгч шалгарч гэрээ байгуулсан, бэлтгэл ажлаа хангаж байна.	30
	Барилга угсралтын үе шатны ажлын гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг “Төслийн удирдлагын арга зүйн заавар” MNS:ISO 21500 стандарт, Барилгын чанарын менежментийн тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр аж ахуйн нэгж, байгууллагуудад сурталчлах	Барилга угсралтын үе шатны ажлын гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг “Төслийн удирдлагын арга зүйн заавар” MNS:ISO 21500 стандарт, Барилгын чанарын менежментийг тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр орон нутгийн тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагуудад сурталчилж, стандартыг нэвтрүүлэх талаарх зөвлөмжийг хүргүүлсэн.	30
	Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй барилгын салбарын аж ахуйн нэгж байгууллагуудын дунд “Барилгын салбарын ажилтны зөвлөгөөн”-ийг жилд нэг удаа зохион байгуулж байх.	Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй барилгын салбарын аж ахуйн нэгж байгууллагуудын дунд “Барилгын салбарын ажилтны зөвлөгөөн”-ийг 2022 оны 09 дүгээр сард зохион байгуулахаар төлөвлөсөн.	ХБ
	Улсын төсөв болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр баригдаж ашиглалтад орсон барилга, байгууламжийн ашиглагч байгууллагыг тодорхойлон, өмчлөлд шилжүүлэх асуудлыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын хүрээнд	2022 оны эхний хагас жилийн байдлаар улсын төсөв болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр баригдаж ашиглалтад орсон барилга байхгүй болно.	ХБ

	шийдвэрлүүлэх, мэдээ тайланг хагас, бүтэн жилд ирүүлэх		
Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам			
1	Төсвийн тухай хуулиар баталсан төсвийн дагуу орон нутгийн халамжийн сангийн төсөв, санхүүжилтийн хуваарийг баталж, баталсан хуваарийн дагуу нийгмийн халамжийн тэтгэмж, үйлчилгээний болон бусад зардлыг аймгийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагын Төрийн сан дахь дансанд сар бүр хугацаанд нь саадгүй, бүрэн санхүүжүүлнэ.	2022 онд нийгмийн халамжийн сангийн 2 төрлийн үйлчилгээнд орон нутгийн төсвөөс 118,5 төгрөг батлагдсанаас онцгой тохиолдлын тэтгэмжид 7 иргэнд 8,4 сая төгрөг, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд 13 иргэнд 1,5 сая төгрөгийн, нийт 20 иргэнд 9,9 сая төгрөгийн үйлчилгээг цаг тухай бүрд нь шуурхай үзүүллээ.	30
2	Хөдөлмөрийн насны зорилтот бүлгийн иргэдийг хөдөлмөрт бэлтгэх сургалтад хамруулах	Зорилтот бүлгийн иргэдэд хөдөлмөрт бэлтгэх сургалтыг зохион байгуулахаар Их үйлсийн бүтээмж сургалтын байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулан сургалтад хамрагдах иргэдийг бүртгэж байна. Удирдамж батлагдахыг хүлээсэн ба сургалтын байгууллагын жагсаалт хүлээгдсэн учир сургалт 6 сарын 20-нд хийгдэхээр бэлтгэл ажил хангагдаж байна.	30
3	Ажилд зуучлах	Сургалт зохион байгуулагдаагүй учир ажилд зуучлагдсан иргэний хувийг тооцох боломжгүй байна.	0
4	Сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, сурталчлах видео бичлэг бэлтгэх	Видео хийгдээгүй байна. Сургалтад хамруулж, ажилд жуучилсны дараа сурталчлах үйл ажиллагааг зохион байна. Хугацаа болоогүй байна. 9 сард хийгдэнэ.	0
5	Зорилтот бүлгийн иргэдийг түр ажлын байраар хангах	Дундговьо ногооруулья өдөрлөг арга хэмжээг аймгийн ЗДТГ-тай хамтран зохион байгуулж “Ногоон ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийг иргэд олон нийтэд сурталчлан хамрагдах хүсэлтэй 300 иргэдийг бүртгэн 5 сумаас төслийг хүлээн аваад байна.	30
6	Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгуулах	ОНОТХҮ-ий санхүүжилтийн хэмжээг нэмэгдүүлэх тухай саналыг тооцоолол үндэслэл бүхий гаргаж аймгийн ИТХ-д оруулснаар 2022 оны төсвийг 27.0 сая төгрөгөөр буюу 30 хувиар нэмэгдүүлж батлуулсан. Эхний 5 сарын байдлаар ОНОТХҮ-нд зорилтот бүлгийн 13 иргэнийг хамруулж 1,5 сая төгрөгийн санхүүжилт зарцуулаад байгаа бөгөөд 6 дугаар сард өдрийн үйлчилгээнд 20 иргэнд 1.8 сая, бүлгийн төсөлд 10 иргэнд 7.5 сая төгрөгийн санхүүжилтийг олгохоор хүлээгдэж буй гүйцэтгэлтэй байна.	30
7	Ажилгүй иргэдийг профайлинг үнэлгээнд хамруулах	Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг 120 иргэн, хувиараа хөдөлмөр эрхлэх хүсэлтэй санхүүгийн дэмжлэгт хамрагдахыг хүссэн 180 нийт 300 иргэнд профайлингийн үнэлгээ хийгээд байна. Үнэлгээ хийх арга зүйн сургалтад 4 сард хамрагдан сумдын мэргэжилтнүүдэд мэдээлэл өгч ажлыг гүйцэтгэсэн ба он дуустал үнэлгээ хийх ажил үргэлжилнэ.	30
8	Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх сургалтад хамруулах	Улсын хэмжээнд бүртгэл зэрэг зарлагдсан ба Залуучуудын оролцоо	30

		төслийн 1-р ээлжийн бүртгэлд нийт 26 залуучууд бүртгүүлж эрүүл мэндийн үзлэгт хамрагдах, ярилцлагад орох 4 ээлжийн үйл ажиллагаа зохион байгуулагдахаас эхний ээлжийн сургалтад тэнцсэн 8 залуучууд сургалтдаа хамрагдаж байна.	
9	Ажлын байрны дадлагад хамруулах	14 хоногийн сургалт дууссаны дараа ирж дадлагад гарна. Хугацаа болоогүй байна.	ХБ
10	Байнгын ажлын байраар хангах	Сургалт дадлага дууссаны дараа ажлын байраар хангана. Хугацаа болоогүй байна.	ХБ
11	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдэд үнэлгээ хийх	Төсөл хэлэлцэж дууссаны дараа тухайн иргэн төслөө хэрэгжүүлэх явцад нь хяналт хийгдэж тул 3-р улиралд зохион байгуулагдана. Хугацаа болоогүй 9 сард хийгдэнэ.	ХБ
12	Дүгнэлтэд үндэслэн шийдвэр гаргах	Хяналт хийгдсэний дараа дүгнэлт гарна. Хугацаа болоогүй	ХБ
13	Хүүхдийн төлөө аймгийн зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх	Хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээр орон нутгийн түвшинд хүүхдийн төлөө шийдвэр гаргах, салбар хоорондын үйл ажиллагааны уялдаа, зохицуулалтыг хангах, хүүхдэд ээлтэй засаглалыг төлөвшүүлэх, хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор аймгийн Хүүхдийн төлөө зөвлөлийн 19 гишүүнд Хүүхдийн эрхийг суурилсан хандлага ба хүүхдийн хамгаалуулах эрх сургалтыг зохион байгуулж, гишүүдийн мэдлэг мэдээллийг нэмэгдүүлж ажиллалаа.	30
14	“Нэгдүгээрт хүүхэд” аймгийн хүүхдийн XIII чуулганыг зохион байгуулах		ХБ
15	Байгууллагуудын гамшгаас хамгаалах болон өвөлжилтийн бэлэн байдлыг хангах төлөвлөгөөг боловсруулахад зөвлөмж өгөх	2022 оны 3,4-р улиралд зохион байгуулахаар ажиллаж байна. Хугацаа болоогүй байна.	ХБ
16	2021 оны Үйл ажиллагааны төсвийн саналыг боловсруулж ИТХ-аар батлуулах	2022 оны эхний хагас жилийн төсвийн зарцуулалтын хувь 45.4 байна.	30
17	Амралт сувилал, рашаан сувилалд хөнгөлөлт эдлэх, амрах ахмадын тоог нэмэгдүүлэх	Амралт, рашаан сувилалд амарсан ахмадын тоо 98 байна.	30
18	Арга хэмжээ нь. Зорилтот бүлгийн иргэдэд асрамж, халамжийн үйлчилгээ үзүүлэх ажлыг батлагдсан төсвийн хүрээнд гэрээний дагуу ТББ-аар гүйцэтгүүлэх ажлыг чанар хүртээмжтэй зохион байгуулж ажилласан байна.	2022 онд ОНОТХҮйлчилгээний гэрийн асрамж халамжийн үйлчилгээг үзүүлэхээр Монголын улаан загалмайн нийгэмлэг үндэсний хүмүүнлэгийн байгууллагын Дундговь дахь салбар Улаан загалмайн хороо ТББ нь ХХҮЕГазраас магадлан итгэмжлэгдсэн байна. Тус байгууллага нь зорилтод бүлгийн иргэдэд 7 дугаар сараас үйлчилгээ үзүүлж эхлэх бөгөөд 10 иргэнд үйлчилгээ үзүүлж 196000 төгрөг зарцуулахаар төсөвлөсөн байна. Хугацаа болоогүй байна.	30
19	Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг ханган ажиллана.	Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний төслийг боловсруулан хэлэлцэж байна	30
20	“Хамтарсан баг”-ийн үйл ажиллагаа, хамгааллын үйлчилгээ, кейс	Хамтарсан багийн дарга, нарийн бичиг нарт зориулсан цахим сургалт 1,	30

	шийдвэрлэлттэй холбоотой зардал санхүүжилтийг шийдвэрлэж, дэмжиж ажиллах	танхимын сургалтыг 2 удаа зохион байгуулж, нийт 15 сумын хамтарсан багийн 68 гишүүн буюу нийт хамтарсан багийн гишүүдийн 34,5%-д мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллалаа.	
21	Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдын аюулгүй байдлыг хангах "Түр хамгаалах байр" бий болгох	Түр хамгаалах байр байхгүй.	0
22	ААН байгууллагад иргэдийн бүтээгдэхүүн, үйлчилгээг танилцуулах өдөрлөг, хэлэлцүүлэг зохион байгуулах	III улиралд хэрэгжүүлэх тул хугацаа болоогүй	0
23	ААН байгууллага, хөгжлийн бэрхшээлтэй болон хүүхдээ асарч буй иргэнтэй гэрээ байгуулах	III улиралд хэрэгжүүлэх тул хугацаа болоогүй	0
24	Ахмад настны тухай хуулийн 8.1.5, 8.1.6 дахь заалт, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 32.8 дахь хэсгийн хэрэгжилтийг хангах	Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийтийн тээврийн хэрэгслээр зорчсон 2021 оны төлбөр болох 27,2 сая төгрөгийн санхүүжилтийг батлуулахаар удаа дараа аймгийн ИТХ-д танилцуулсан боловч Засаг даргын зардлын ангилалд байхгүй тул батлах боломжгүй гэсэн шийдвэр гарсан. Мөн сангийн яамнаас аймгуудад хуваарилсан батлагдсан төсвийн суурь зардалд тусгаагүй тул төлөх боломжгүй байна.	0
25	Хохирогч хамгаалах түр хамгаалах байрны стандарт /MNS 6040:2019/- ыг хэрэгжүүлэх, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх хүний нөөцийг бүрдүүлэх, тогтвор суурьшилтай ажиллуулах, санхүүжилтийг орон нутгийн төсөвт тусгах	"Түр хамгаалах байр бий болгох" төслийн саналыг ЗГХА ГБХЗХГ-ын дарга Г.Батдорж, УИХ-ийн гишүүн Г.Мөнхцэцэг, С.Батболд, Австралийн элчин сайдын яаманд тус тус хүргүүлж ажиллалаа.	0
26	Эрэгтэйчүүдийн эрсдэлтэй зан үйлд нөлөөлөх хөтөлбөр хэрэгжүүлэх	Гэр бүлийн зөрчилдөөнтэй асуудлыг хүч хэрэглэж шийдвэрлэхээс урьдчилан сэргийлэх, түүний хор уршгийг ойлгуулах зорилгоор Зан үйлд нөлөөлөх сайн дурын сургалтыг хөтөлбөрт тусгагдсан сэдвүүдийн дагуу 52 иргэнд 208 цагийн сургалтыг зохион байгууллаа.	30
27	Хүүхдийн ордон, зуслангийн үйл ажиллагаанд үнэлгээ хийж, хүүхдийн хамрагдалтыг нэмэгдүүлэх /хүүхдийн хамрагдалтын өсөлтийн хувь/	Аймгийн "Тэнгэрийн тэмдэг хүүхдийн театр"-тай хамтран нийт 7 төрлийн дугуйланд, 254 хүүхдийг хамруулаад байна. Бүрдийн уянга хүүхдийн зуслан нь 2022 оны 06 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн амрагчдаа хүлээн авахаар ээлжийн хуваарийг батлуулж ажиллалаа. Засаг даргын захирамжаар ажлын хэсэг гарч очиж ажиллах бэлтгэл ажил хийгдэж байна. 7 сарын 1-ний дотор тайланг хүргүүлнэ. Хүүхдийн ордон, зуслангийн үйл ажиллагаанд хамрагдалт өмнөх оныхоос 14 хувиар өссөн үзүүлэлтэй байна.	30
28	Гэр бүлийн хохирогчийг хамгаалах "Түр хамгаалах байр"-ыг стандартын дагуу байгуулж, ажиллуулах	Түр хамгаалах байр байхгүй, шаардлагатай иргэдийг Улаанбаатар луу зөөж үйлчилгээ үзүүлж байна. "Түр хамгаалах байр бий болгох" төслийн саналыг ЗГХА ГБХЗХГ-ын дарга Г.Батдорж, УИХ-ийн гишүүн Г.Мөнхцэцэг, С.Батболд, Австралийн элчин сайдын яаманд тус тус хүргүүлж ажиллалаа.	0

29	Хүүхэд харах үйлчилгээг хэрэгжүүлнэ.	Аймгийн хэмжээнд хүүхэд харах үйлчилгээ эрхэлдэг иргэн, аж ахуй нэгж байхгүй учраас 2022 оны байдлаар хүүхэд харах үйлчилгээний төсөв батлагдаагүй.	0
30	Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, Залуучуудын салбар зөвлөлийн төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг ханган тайлагнах	Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, гишүүдийн үүрэг оролцоог нэмэгдүүлэх зорилгоор аймгийн Залуучуудын салбар зөвлөлийн 34 гишүүнд "Залуучуудын салбар зөвлөлийн гишүүдийг чадавхжуулах нь" сэдэвт сургалтыг зохион байгууллаа. Сургалтын үеэр соёлын байгууллагуудын дэргэдэх Залуучуудын хөгжлийн зөвлөлийг байгуулан батламжийг гардуулан өглөө.Залуучуудын салбар зөвлөлийн хуралдааныг 1 удаа зохион байгуулж, төлөвлөгөөний хэрэгжилт 50 хувьтай байна.	30
31	Залуучуудын хөгжлийг дэмжих орон нутгийн дэд хөтөлбөрийг батлан, хэрэгжилтийг хангаж ажиллах		0
31	Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид үзүүлэх хамгааллын үйлчилгээний etuslamj.mn мэдээллийн санг бүрдүүлэх, тайлагнах, мэдээллээр хангах	Түр хамгаалах байр байхгүй тул etuslamj.mn мэдээллийн санг бүрдүүлэх боломжгүй байна.	0
32	Улсын төсөв, орон нутгийн төсөв, гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламж, хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт, Засгийн газрын тусгай сангууд болон хувийн аж ахуйн нэгж, байгууллага болон бусад хөтөлбөр, төслийн хүрээнд байнгын ажлын байр шинээр бий болгоно.	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, ЖДҮХСан, Орон нутгийн хөгжлийн сангийн зээлүүд олгогдоогүй байна. Шинэ ажлын байр гараагүй учир буурсан үзүүлэлттэй байна.	0
33	Дэд бүтэц, хөрөнгө оруулалт, санхүү зээлийн бодлогын уялдааг хангаж зохистой хөдөлмөрийн бодлого, зорилтыг орон нутгийн онцлогт нийцүүлэн тодорхойлж хэрэгжүүлснээр тогтвортой хөдөлмөр эрхлэлтийн түвшинг дээшлүүлнэ.	2021 суурь үзүүлэлт 73 % байсан. 2022 оны 1-р улирлын хөдөлмөр эрхлэлтийн түвшин 68.8 байна. Өмнөх оны 1 улирлын байдлаар хөдөлмөр эрхлэлтийн түвшин 73% байсан бөгөөд энэ оны мөн үетэй харьцуулахад 4.2% буурсан үзүүлэлттэй байна.	0
34	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд заасан ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах, ажилд зуучлах үйлчилгээ болон Засгийн газар, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс баталсан ажилгүйдлийг бууруулах, хүн амын бүлгүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих "Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр", "Аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр", "Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр", "Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр", "Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр" "Ногоон ажлын байр хөтөлбөр" "Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	Суурь түвшин 68, хүрэх түвшин 75 ба сургалтад хамруулаад төсөл сонгон шалгаруулалт хийгдсэн. Ногоон ажлын байрыг дэмжих хөтөлбөрт хамрагдах хүсэлтэй 300 иргэдийг бүртгэн 5 сумаас төслийг хүлээн аваад байна. Суурь түвшин-246, хүрэх түвшин 286 байх ба хүрсэн түвшин-0. Суурь түвшин-988, хүрэх түвшин 1186 ба хүрсэн түвшин-517 байна. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх мэдээллээр хангах үйлчилгээнд 316 иргэн хамруулан 248 сул чөлөөтэй ажлын байрны захиалга ирснээс 201 иргэнийг ажлын байранд зуучлаад байна.	30

	хөтөлбөр"-ийн хүрээнд төсөл, арга хэмжээг хэрэгжүүлнэ.		
35	Өрхийн үйлдвэрлэл эрхлэгч, аж ахуйн нэгж, нөхөрлөл, хоршооны хэлбэрээр бичил бизнес эрхлэгчдэд жижиг зээл олгох арга хэмжээг хэрэгжүүлнэ.	Суурь түвшин-4, хүрэх түвшин 5 байх ба одоогоор Бичил бизнесийг дэмжих жижиг зээл олгох арга хэмжээг иргэд олон нийтэд нээлттэй зарлан хамрагдах хүсэлтэй иргэдийг сумдын хөдөлмөр эрхлэлт халамжийн асуудал хариуцсан мэргэжилтнүүд бүртгэж байна. Сонгон шалгаруулалт 7-р сард зохион байгуулагдана. Холбогдох журам, төсөв батлагдан ирээгүй байна.	0
36	Нутаг дэвсгэрийн аж ахуйн нэгж, байгууллагуудад шинэчлэн тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс багагүй цалин хөлс олгохыг мөрдүүлж, хэвшүүлнэ.	Хийгдээгүй байна. 4 дүгээр улиралд ХАБЭА-н үзлэгтэй хамт хийгдэнэ.	0
37	Орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх Олон нийтийн оролцоонд түшиглэсэн нийгмийн халамжийн үйлчилгээ, онцгой тохиолдлын тэтгэмжийн санхүүжилтийг бүрэн олгож, үйлчилгээг үр дүнтэй хэрэгжүүлэх	Суурь түвшин -141, хүрэх түвшин 296 ба хүрсэн түвшин - 20.	20
38	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэдээллийн хүртээмжийг сайжруулах ажлыг зохион байгуулах	Байгууллагын цахим хуудсыг хөгжлийн бэрхшээлтэй хүнд ээлтэй болгох, сайжруулах саналыг ХХҮЕГазрын Мэдээлэл технологийн газарт хүргүүлсэн.	0
39	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбар зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоотой үнэлэх	Төлөвлөгөөний хэрэгжилт 40 хувийн биелэлттэй байна.	40
БОАЖЯам			
1	Байгаль орчин, аялал жуулчлалын газрын албан хаагчдын нийгмийн баталгааг хангахад дэмжлэг үзүүлэх	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг шинжилгээнд 1 албан хаагч хамрагдсан. 20 албан хаагчийн үзлэгт хамрагдах урилгыг авсан. Усны асуудал, тусгай хамгаалалттай газар нутаг хариуцсан 2 мэргэжилтэнд нөүтбүүк өгсөн.	50
2	Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлийг дэмжих	Аймгийн 15 сум бүрт "Малчдын зөвлөгөөн"-ийг зохион байгуулж 3626 малчин оролцсон. Зөвлөгөөнөөр сум бүрийн онцлог давуу талыг түшиглэн шинээр хоршоо, нөхөрлөл байгуулж, орлогоо нэмэгдүүлэх чиглэлээр сургалт, мэдээллийг хүргэсэн.	30
3	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам"-ын 4.8 дахь заалтын хэрэгжилтийг хангах	Газрын төлбөрийн орлого 159791.0 мянган төгрөг, усны төлбөрийн орлого 52015.0 мянган төгрөг, ан амьтны нөөц ашигласны төлбөр 18.0 мянган төгрөг орсон.	50
4	Сангийн сайд, Байгаль орчны сайдын хамтран баталсан 2006 оны 342/366 дугаар тушаал "Байгаль орчны хууль тогтоомжийн зөрчлийг илрүүлсэн буюу зөрчлийн талаар бодит мэдээлэл өгсөн иргэнд уламшуулал олгох журам"-ын хэрэгжилтийг хангах	Идэвхтэн байгаль хамгаалагчаар ажиллах журмын талаар танилцуулга, мэдээлэл хийж Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын 2022 оны Б/11 дугаар тушаалаар аялал жуулчлалын бүсэд шинээр 13 идэвхтэн байгаль хамгаалагчийг томилсон. Торгууль нөхөн төлбөр оруулаагүй.	50

5	“Иргэн бүр байгаль хамгаалагч” уриан дор байгаль орчныг хамгаалах, зөв дадал зуршил бий болгох зорилгоор нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлэх	Шинээр нөхөрлөл бүртгэгдээгүй. Байгалийн үзэсгэлэнт газар жуулчны бааз, амралтын газрын үйл ажиллагаа эрхэлдэг баазуудын удирдлага, менежер, харуулыг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын 2022 оны Б/11 дугаар тушаалаар аялал жуулчлалын бүсэд 13 идэвхтэн байгаль хамгаалагчийг томилсон.	50
6	Үйлдвэрлэл үйлчилгээний /уул уурхай, аялал жуулчлал, ШТС./ бүс дэх нүхэн жорлонг үе шаттайгаар стандартын шаардлагад нийцүүлнэ	Говь-Угтаал суманд уул уурхайн үйл ажиллагаа явуулдаг 1 ААНэгж 2 ширхэг эко ариун цэврийн байгууламжтай болсон бөгөөд үйлдвэрлэл, үйлчилгээний бүс дэх эко ариун цэврийн байгууламжийн эзлэх хувь 26.5 хувьд хүрэв. Хувийн хэвшлийн 0.6 сая төгрөг зарцуулав.	30
7	Агаарын чанарыг сайжруулах бүсэд мөрдөх журмыг шинэчлэн батлах	Агаарын чанарын бүсийг шинэчлэн тогтоохоор төслийг боловсруулан БОАЖЯамны холбогдох мэргэжилтэнд хүргүүлсэн ба Захиргааны ерөнхий хуулийн дагуу олон нийтээс санал авахаар байгууллагын болон аймгийн цахим хуудсанд байршуулсан.	ХБ
8	Аюултай хог хаягдлыг түр хадгалах агуулахын менежментийг хариуцах байгууллагыг сонгон шалгаруулах		ХБ
9	Аюултай хог хаягдлыг түр хадгалах агуулахыг барьж дуусгаж, хэвийн үйл ажиллагааг хангах нөхцөлийг бүрдүүлэх		ХБ
10	Ашиглалтад өртөн нөөц хомстож буй 1 зүйл ургамлын үрийн жишиг плантаци байгуулах	Ховор ургамлын жагсаалтад орсон шивүүрт цулхир / <i>Agriophyllum pungens</i> (Vahl)Link/ ургамлыг Сум дундын ойн ангитай хамтран ургамлыг тариалж 60 мкв талбайд плантаци байгуулах ажлыг эхлүүлэв.	30
11	Уул уурхай болон дэд бүтцийн улмаас эвдэрсэн газрын тооллого зохион байгуулах	Уул уурхай болон дэд бүтцийн улмаас эвдэрч орхигдсон газрын суурь судалгааг зохион байгуулсан ба нийт 7 суманд 59.25 га газар бүртгэгдээд байна. Тооллогыг мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулан нарийвчлан гүйцэтгүүлнэ.	50
12	Эвдэрч, эзэнгүй орхигдсон талбайд нөхөн сэргээлт хийх	Уул уурхайн ашиглалтын үйл ажиллагаа явуулдаг 11 ААНэгжийн БОМТөлөвлөгөөнд эвдэрч, эзэнгүй орхигдсон 10 га газарт нөхөн сэргээлт хийлгэхээр тусгуулсан.	ХБ
13	Аймгийн төвийн ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн хориглолт хязгаарлалтын бүсийг шинэчлэн тогтоож, хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх		ХБ
14	Бага газрын чулуу” улсын тусгай хамгаалалттай газрын угтах хэсгийг тохижуулах	“Бага газрын чулуу” улсын тусгай хамгаалалттай газарт мэдээллийн самбар бүхий 1 угтах хаалга, ангилан ялгах хогийн сав байршуулах гэрээг байгуулж, тохижилтын ажлыг хийх бэлтгэл ажлыг хангав.	30
15	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх стратеги	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөөг боловсруулж байна.	ХБ

	төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг хангаж ажиллах		
16	Хашиж хамгаалах, тэмдэгжүүлэх ажилд мод ашиглахаас татгалзах, хуванцар болон бусад хог хаягдлыг дахин ашиглах нөхцөлийг бүрдүүлж, худалдан авалтын бодлогоор дэмжих “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалтыг хэрэгжүүлэх арга хэмжээг авах	8 га талбайд хамгаалалтын ойн зурвас байгуулах ажлыг улсын төсвийн 90 сая төгрөгийн санхүүжилтээр, “Цагаан суварга” орон нутгийн тусгай хамгаалалттай газар орчимд улсын төсвийн 100 сая төгрөгийн хөрөнгөөр аялал жуулчлалын отоглох цэг байгуулах, нийт 2 тендерийн ажлын даалгаварт хашаа, тэмдэгжүүлэлт, шонг хог хаягдлыг дахин боловсруулж хийсэн материал ашиглах талаар ажлын даалгаварт тусган шалгарсан 1 ААНэгжтэй гэрээ байгуулан 1 ААНэгжид мэдэгдэл хүргүүлсэн.	50
17	Аялал жуулчлалын нэгдсэн бодлого менежментийн төлөвлөгөөг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж, батлуулах	Барилга, хот байгуулалтын яамны санхүүжилтээр Өлзийт сумын Цагаан суваргын аялал жуулчлалын бүсийн ерөнхий төлөвлөгөөг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгэх тендерийг зарлаж ирүүлсэн компаниудын материалыг хянан үзэж байна.	30
18	Монголын нүүдлийн соёлын онцлогт тохирсон морь, тэмээн аялал зохион байгуулж, нутгийн иргэдийг аялал жуулчлалд холбох	Говь-Угтаал сумын Засаг даргын Тамгын газартай хамтран малчин иргэдийг аялал жуулчлалд холбох, морин аялал зохион байгуулахад аргагүйн дэмжлэг, туслалцаа үзүүлж Хустайн байгалийн цогцолборт газрын “Баян сонгинот” нөхөрлөл болон Тэрэлжид морин аяллын газарт туршлага солилцох аяллыг хийсэн. Мөн Германы хамтын ажиллагааны нийгэмлэгээс тус сумын малчин иргэдэд зориулсан морин аялал хийх сургалтад 14 малчин хамрагдсан. (Зураг хавсаргав)	30
19	Байгаль, түүх, соёлын аялал жуулчлалын эвент арга хэмжээг зохион байгуулах	Дэлгэрхангай сумын Засаг даргын Тамгын газартай хамтран 2022 оны 02 дугаар сарын 17-ны өдөр “Тэмээний баяр” зохион байгуулсан. Тус эвент арга хэмжээнд 7 сумын 74 тэмээчин оролцож, 230 хүн үзэж сонирхсон.	50
20	Жуулчдын аюулгүй байдлыг хангах чиглэлээр дундын хамтын ажиллагааг сайжруулах	Их газрын чулуу байгалийн цогцолборт газар аяллын маршрутын дагуу зүг чиг заасан 18 тэмдэг байрлуулж аялагч, жуулчдын аюулгүй байдлыг хангав. “Зөв аялъя” уриалган дор аялал жуулчлалын маршрут, жуулчны баазуудын мэдээллийг нэгтгэн Аялал жуулчлал, байгаль орчны сайт, цахим хуудаст байрлуулж аялагчдыг мэдээллээр хангав.	50
21	Аялал жуулчлалын асуудал хариуцсан мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалтад хамруулах	Аялал жуулчлалын үндэсний зөвлөгөөний хүрээнд “орон нутгийн аялал жуулчлалын хөгжлийн асуудал” сургалтад хамрагдсан.	50
22	Аялал жуулчлалын салбарын гадаад сурталчилгааг идэвхжүүлж, цахимжуулах	Аялал жуулчлалын газрын зургийг солонгос хэл дээр хэвлүүлж “УЛААНБААТАР ТРАВЭЛ ЭКСПО- 2022” Үндэсний аялал жуулчлалын үзэсгэлэнгийн үеэр 150 ширхгийг тараав. Мөн аймгийн аялал жуулчлалын маршрут, жуулчны бааз, зочид буудал, бэлэг дурсгалын үйл ажиллагаа	30

		эрхлэгчдийн нэгдсэн гарын авлагыг бэлтгэж мэдээллийн сан үүсгэв.	
23	Статистик үзүүлэлт тооцох аялал жуулчлалын дагуул дансны аргыг нэвтрүүлэх суурь судалгаанд мэдээ мэдээллээр хангах	Статистик үзүүлэлтийг тооцох дагуул дансны аргачлалыг нэвтрүүлэхэд холбогдох мэдээллийг хүргүүлсэн.	30
24	Цөлжилтийг сааруулах, газрын доройтлыг зорилгоор хамгаалалтын ойн зурвас байгуулах	20 га талбайд ойн зурвас байгуулах ажлын техникийн тодорхойлолтыг Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хүргүүлсэн. Тендерийг зарлаж намрын мод тарилтаар ажлыг гүйцэтгэнэ.	ХБ/0
25	Цөлжилт, газрын доройтолд өртсөн газарт хамгаалалтын зурвас байгуулах	Цөлжилт, газрын доройтлыг бууруулах, элсний нүүдлийг сааруулах зорилгоор Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2022 оны А/28 дугаар тушаалаар Дундговь аймагт 8 га талбайд хамгаалалтын ойн зурвас байгуулахад зориулан 90 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэсэн ба тус аймгийн Эрдэнэдалай суманд хэрэгжүүлэхээр төлөвлөн худалдан авах ажиллагаа зохион байгуулан “Тэнгэрлэг ой” ХХК-тай гэрээ байгуулсны дагуу 2 га талбайд 1500 ширхэг суулгац тарив.	30
26	Аялал жуулчлалын байгаль, түүх, соёлын өв бүхий газруудад ариун цэврийн газар, авто зогсоол бүхий отоглох цэг байгуулах	Аймгийн Тамгын газрын даргын 2022 оны 02 дүгээр сарын 22-ны өдрийн А/45 тоот тушаалаар “Дундговь аймгийн Цагаан суварга орчмын аялал жуулчлалын бүсэд отоглох цэг байрлуулах” гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороо байгуулж тендерийг зарлаж “Хангда” ХХК шалгарч гэрээ байгуулах мэдэгдэл хүргүүлсэн. “Их газрын чулуу” байгалийн цогцолборт газарт отоглох цэг байгуулах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороонд 3 компани материал ирүүлснээс шаардлага хангасан компани байхгүй дүгнэлт гарсан. Аймгийн хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсээс шууд гэрээ байгуулахаар болсон.	30
Хууль зүй дотоод хэргийн яам			
1	Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн иргэдийг түр хамгаалах байр байгуулж, сэтгэл зүйн тусламж, зөвлөгөө, мэдээллээр үйлчлэх үйл ажиллагааг нь тогтмолжуулах.	Цагдаагийн газрын ашиглаж байсан хуучин барилгыг засварлаж, “Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн иргэдийг түр хамгаалах”, “Иргэдийг гэр бүлийн хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх зөвлөгөө, мэдээллээр үйлчлэх төв”-ийг байгуулахаар Аймгийн Засаг даргад хүсэлт хүргүүлж, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газраар зураг төсвийг гаргуулсан. Тайлант хугацаанд гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг 8 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үестэй харьцуулахад 2 дахин, зөрчил 27 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.6 дахин өссөн үзүүлэлттэй. Аймгийн Гэр бүл хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын сэтгэл зүйчид холбон зуучилж хүчирхийлэлд өртсөн 35 иргэнд сэтгэл зүйн тусламж	30

		үйлчилгээ үйлчилгээ, зөвлөгөө мэдээллээр ханган ажилласан.	
2	Аймгийн Шүүхийн шинжилгээний албаны мэргэжлийн лабораторыг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах	Тус алба хими, биологийн лаборатори байгуулахаар шаардлагатай тоног төхөөрөмжийн судалгааг лабораторийн тоног төхөөрөмж нийлүүлэгч “Грийн Химистри” ХХК-тай хамтран үнийн судалгааг гаргаж, 2022 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 13и/99 тоот албан бичгээр хүргүүлсэн.	30
3	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.3 дахь хэсэгт “Орон нутгийн төсвийн хөрөнгөөр нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байр байгуулах саналаа иргэдийн төлөөлөгчдийн хуралд өргөн мэдүүлэх, гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах” гэж заасны дагуу харьяалах нутаг дэвсгэртээ байгуулсан түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвийн тогтвортой үйл ажиллагааг хангаж ажиллана.	Тус аймаг дахь Цагдаагийн газрын ашиглаж байсан хуучин барилгыг засварлаж гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн иргэдийг байрлуулах “Түр хамгаалах байр”-ыг байгуулах хөрөнгийг шийдвэрлэх талаар холбогдох газруудад хүсэлт хүргүүлж, зураг төсвийг гаргасан. Монгол улсын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албаны дарга Л.Нямгэрэлийг тус орон нутагт ажиллах үеэр гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг үйлдэгдэх гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдлыг танилцуулж, “Түр хамгаалах байр”-ны асуудлыг шийдвэрлэх нэн шаардлагатай байгаа талаар танилцуулсан.	30
Батлан хамгаалах яам			
1	Сум, багийн Засаг дарга, ЗДТГ-ын дарга нарын “Цэргийн бэлтгэл”, сургалтыг зохион байгуулах, төсөв хөрөнгийг шийдвэрлэх		ХБ
2	Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж буй иргэдийн сургалтыг зохион байгуулах		ХБ
3	Хугацаат цэргийн алба хааж буй дайчдын цэргийн албаны үйл ажиллагаатай танилцах, тэдний ар гэрт нь дэмжлэг, туслалцаа үзүүлэх		ХБ
4	Дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний сургалтыг зохион байгуулах	Засгийн газрын төсвийн хэмнэлттэй холбогдуулан БХЯ-наас Дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний сургалтыг энэ жил явуулахыг цуцалсан.	0
5	Цэргийн штаб, батлан хамгаалахад туслах олон нийтийн байгууллага хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх		ХБ
6	Аймгийн цэрэг-стратегийн үнэлгээг нийгэм, эдийн засгийн статистик үзүүлэлтэд үндэслэн цэргийн болзошгүй ажиллагаанд үзүүлэх нөлөөллийг бодитоор боловсруулж, дүгнэлт гаргах		ХБ
Соёлын яам			
1	Орон нутгийн өөрсдийн онцлогт нийцсэн соёлын бүтээлч үйлдвэрлэл, соёлын аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээний нэр, төрлийн судалгааг нарийвчлан гаргаж, цаашид брэнд болгон хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх.		ХБ
2	Хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах, мэргэжил дээшлүүлэх талаар холбогдох сургалтыг зохион байгуулж, дэмжлэг	Соёлын яам, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газар, Соёл, урлагийн их сургууль, аймгийн Хяналт Шинжилгээ үнэлгээний	50

	үзүүлэх, мэргэжлийн хүний нөөцийг бүрдүүлэн тогтвортой ажиллуулах.	хэлтэс, Соёл, урлагийн газраас зохион байгуулсан нийт 9 төрлийн цахим болон танхимын сургалтад давхардсан тоогоор 225 ажилтан албан хаагчдыг хамруулсан. Соёлын төвийн дарга, бүжгийн багш, хөгжмийн багш, номын санч, өвийн ажилтнуудад зориулсан 2 кредит мэргэшүүлэх сургалтад 35, мэргэжлийн соёл урлагийн байгууллагын ажилтнуудад зориулсан “Оюуны өмч” сургалтад /4 долоо хоног/ 5 ажилтан, “Хүний хөгжлийг дэмжих нь” арга зүйн сургалтад 72, “Нэгжийн түвшинд жендэрийн мэдрэмжтэй төлөвлөлтийн аргачлалыг ашиглах” нь цахим сургалтад 56, Гэр бүл, хүчирхийллийн эсрэг сургалтад 15, ХШҮ-ний хэлтсийн бодлого төлөвлөлт, үнэлгээ тайлагналтын сургалтад 36, Оюуны өмчийн үнэлгээний онцлог сэдвүүдээр цахим сургалтад 4, e-mongolia, ер системийн ашиглалтад 2 ажилтныг тус тус хамрууллаа. Эхний хагас жилийн байдлаар салбарын мэргэжилтэй ажилтны эзлэх хувь 64-д хүрсэн нь өмнөх оноос 1,7%-иар нэмэгдүүлсэн.	
3	Соёл урлагийн ажилтнуудыг "Бүсчилсэн зөвлөгөөн"-нд оролцуулахад дэмжлэг үзүүлэх		ХБ
4	Соёлын төв, соёлын ордны дүрмийг шинэчлэн батлах ажлыг зохион байгуулах	14 Соёлын төвийн нийт 54 ажилтныг хамруулан хэлэлцүүлэг зохион байгуулж, саналыг нэгтгэн үлгэрчилсэн дүрмийн төслийг бэлтгэж, батлууллаа.	50
5	"Мэргэжлийн урлагийн байгууллагын менежментийн чадавхыг бэхжүүлэх сургалт"-ыг зохион байгуулах		ХБ
6	Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллого хийж, тайлагнана.		ХБ
7	Соёлын биет бус өвийн бүсчилсэн судалгааны ажлыг зохион байгуулна.		ХБ
8	"Төв Азийн Тууль" III симпозиум, наадмыг зохион байгуулна.		ХБ
9	"Нүүдэлчин Монгол" наадам зохион байгуулахад дэмжлэг үзүүлнэ.		ХБ
10	Уламжлалт аргаар хөтөлсөн угийн бичиг болон баримтат өвийг сурвалжлан олж бүртгэх, сурталчлах ажлыг зохион байгуулна.	Угийн бичигтэн өрх" шалгаруулах зорилгоор болзлын төслийг боловсруулан 18 соёл, урлагийн байгууллагын төлөөллийг оролцуулан хэлэлцүүлж, гарсан саналыг тусган батлуулахад бэлэн болгоод байна. Сумдын 14 соёлын төвийн угийн бичиг хөтлөлт хариуцсан ажилтнуудтай хамтран уламжлалт аргаар хөтөлсөн угийн бичгийг сурвалжлахад Эрдэнэдалай сумаас 4, Сайхан-Овоо сумаас 2, Адаацаг сумаас 1, нийт 7 бичгийг олж илрүүлэн бүртгэлээ.	50
11	Аймгийн музейн сэдэвчилсэн цомгийг бэлтгэж хэвлүүлнэ.		ХБ
12	Аймгийн төв, сум, суурин газрыг соёлын өвөрмөц, дахин давтагдашгүй хэв шинжийг агуулсан "БҮТЭЭЛЧ ХОТ"		ХБ

	хэлбэрээр хөгжүүлэх үзэл баримтлал боловсруулах		
13	"Төв халх" дуулалт жүжгийн театр /Дундговь, Сайнцагаан сум/	Соёлын сайд Ч.Номинг аймагт ажиллах үеэр барилгын ажлыг үргэлжлүүлэх талаар хүсэлт тавьсан. Санхүүжилт олгоогүй.	0
14	Соёлын төвийн барилга, 150 суудал /Дундговь, Дэлгэрхангай сум/	Хэмнэлтийн тухай хуулиар санхүүжилт нь татагдсан.	0
ЗГХЭГ			
	Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2022 онд санхүүжихээр заасан дараах хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн худалдан авах ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн 3 дугаар сарын 1-ний өдрийн дотор зохион байгуулах;	2022 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 5 яамнаас эрх шилжиж ирсэн 10,9 тэрбум төгрөгийн 13 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар төлөвлөсөн бөгөөд үүнээс Засгийн газрын хэрэг эрхлэх газраас эрх шилжиж ирсэн 392,1 сая төгрөгийн 2, Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас эрх шилжиж ирсэн 3 тэрбум төгрөгийн 2 төсөл арга хэмжээний санхүүжилт татагдаж 7 тендер шалгаруулалт амжилттай зохион байгуулагдаж гэрээ байгуулагдсан төлөвтэй байна. Байгаль орчин аялал жуулчлалын яамнаас эрх шилжиж ирсэн Аялал жуулчлалын байгаль, түүх, соёлын өв бүхий газруудад ариун цэврийн газар, авто зогсоол бүхий отоглох цэг байгуулах ажлын гүйцэтгэчийг сонгох тендер шалгаруулалт амжилтгүй болж дахин зарлах шатанд байна.	50
	Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2022 онд санхүүжихээр заасан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын багцаас захиалагчийн эрх шилжүүлсэн 392.1 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг шуурхай зохион байгуулж, төсөл, арга хэмжээний үе шат бүрд тавих техник хяналт, захиалагчийн хяналтыг холбогдох хууль, дүрэм журмыг баримтлан хариуцлагатай хийх;	Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас эрх шилжиж ирсэн 392,1 сая төгрөгийн 2 төсөл арга хэмжээний тендер шалгаруулалтыг шуурхай зохион байгуулан шалгарсан оролцогчид гэрээ байгуулах эрх олгосон боловч санхүүжилт татагдсан байна.	0

Цаашид анхаарах асуудал:

Хэрэгжилт удаашралтай байгаа болон хугацаа болоогүй заалтуудыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан хэрэгжилт үр дүнг нэмэгдүүлэх арга хэмжээ авах

ТАЙЛАНГ ХЯНАСАН:
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН ДАРГА Г.САМДАНЦООДОЛ

ТАЙЛАН БИЧСЭН:
ХШҮХ-ИЙН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Э.ОДОНЧИМЭГ